

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ёндонжамц, Даваасүрэн	Дугаар	L225
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Орхон сумын Халиун баг
Төрсөн газар	Орхон сум	Төрсөн он	1923, 1943
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	<a href="#">Нарийн Чингэлийн хурал</a>	Сүм хийдийн дугаар	БУОР 052
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ц.Мөнхбат



Булган аймгийн Орхон сумын Нарийн Чингэлийн хурал

Мөнхбат:Манай Энэ туурин дээр 3 дуганы туурь тод харагдаж байна. Нэг туурины ивээсийн чулуунууд бол яг байрандаа зоогдсон хэвээрээ байна. Нөгөө 2 туурь бол газрын хөрснөөс дээш 25-30 см-ийн өндөрт өргөгдөж шороон далан үүссэн байдалтай үлдсэн байна. Энэ 2 дуганы суурийн чулуунууд байхгүй болсон байна. Манай ажилд газарчилж яваа Халиун багийн уугуул одоо 63,64 настай Даваасүрэн гуай, мөн Халиун багийн засаг даргаар олон жил ажиллаж байсан энэ нутгийнхаа түүхийг сайн мэддэг Ёндонжамц гуай нар оролцож байна. Энэ хавьд Цэнгэлийн дуганд сууж байсан хүмүүс төдийлөн байхгүй байна тэгэхлээр нутгийн энэ хүмүүстэй бид дараах ярилцлагыг хийсэн юм. Энэ нутаг оронд энэ голд бага насаа үдэж бүхий л насаа өнгөрөөж байгаа та бүхний хүүхэд насанд энэ дуганууд ямархуу байдалтай байсан бэ, хариуцдаг хүн байсан уу үгүй юу? Энэ дуганууд хаашаа яаж алга болсон бэ?

Ёндонжамц:За би Ёндонжамц гэдэг хүн байна. Би энэ нутгийн унаган хүн. Би их сайн санаж байна 56 онд манайх яг энэ туурины ард намар гүү бариад байж байлаа. Тэрийг яагаад мэдэж байна гэвэл мийний дүү 55 онд гарсан юм. 56 онд манайх дүүгийн үсний ойг хийх гэж гүү барьж айраг цагаа бэлдэх гэж намар байж байсан

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юм. Тэгэхэд энэ бол одоо 3 туурь байна, тэгэхэд энд бол зөндөө олон байшин байсан. Бид нар энд 5 хүүхэд тоглож байлаа, тэр үед 56 онд. Хөөргөөр тоглоно, номоор тоглоно, бурхан, алдас болох вий дээ Дарь Эх минь, айж байна. Номнууд нь дандаа энэ зүүн тийшээ, хийсээд л байна хийсээд л байна дандаа энэ жалга руу орсон, ном нь хийсээд л байна, хийсээд л байна. Зөндөө олон дуган байшингуудтай, тэнд яхав дандаа шавар бурхангууд байсан даа алтан, мөнгөн бурхангууд нь байгаагүй, хөөрөг энэ тэр бол зөндөө, манан хөөрөг, өөр юу юу ч гэдэг юм бүү мэд, тэрүүгээр бид нар тоглоод хийсгэж байлаа. Тэрнээс өөр юм мэдэхгүй юм. Би чинь 49 оны хүн юм чинь 56 он гэхэд 7 настай сургуульд ороо ч үгүй байсан, 10 нас хүрч байж хожуу орсон хүн. Тийм юм санах юм. Үнэхээр гоё байшингууд байсан, дээр нь гарчихна, доор нь орно, дотор нь орно, хэвтэнэ ном момын хийсгэнэ тийм л байлаа.

Мөнхбат:За, Даваасүрэн гуй.

Даваасүрэн: За би Даваасүрэн гэдэг хүн байна. Энэ нутагт би үхэр мал хариулаад байдаг байлаа, засгийн үхэр. Тэгэхэд энэ байшин хашаа нь хэвээрээ байсан. Тэрнээс хойш ном судар нь хийсээд л миний аав, ээж чинь энүүгээр газар дээр нь шээж баав гэдэг, элдэв, шилдэв л юм байсан. Одоо ч байшин хашаа чбайхгүй дуганы суурь л гэж нэрлэгдэж байгаа юм байна. Өөр миний мэдэх юм алга. Байшин байсан, миний мэдэхийн.

Мөнхбат:Тууриас зүүн хойшооноо нэг зуугаас, зуун тавиад метрийн зайд Өндрийн овоо гэсэн энэ нутгийн энэ овоо та бүхэн тахисан юм байнаа, өчигдөр. Энэ овоо эртний тахилгатай овоо байж, та нар уламжлаж тахиж байна уу, эсвэл шинээр тахиж ёслолыг хийв үү?

Ёндонжамц: Энэ эртнийх ээ. Бүр эртнийх бидний хүүхэд байхаас эртний овоо. Тэр нь гол овоо, гол овоогоо тойроод 13 овоо байна. Дээр үед их сайхан тахиж байсан Өндрийн Овоо гэж нэрлэдэг байсан. Энэ дор нэг дуган сүм байсан юм гэнэ лээ.

Дуган гэж. Эндэхийн ерөнхий лам, ерөнхийлөгч гэдэг юм уу, хамба лам тэр нь энийг анх үүсгэсэн. Их сайхан овоо байдаг юм байна. Их сайн дурандах юм бол эндээс УБ хотын Богд уул харагддаг гэж байгаа. Их ч юм харагддаг юм билээ. Уул усаа тахилаа, шүтлээ өчигдөр, ийм учиртай эртнийх шүү эртнийх.

Мөнхбат:Халиун сумын нутагт байгаа Цэнгэлийн хийд бол харьцангуй бусад хийдийг бодох юм бол хогийн ургамалд дарагдаагүй, түүрийн чулуунууд хэвэндээ байгаа. Одоо ингээд айлын хаваржаа болчихжээ. Тэгэхлээр хүн малын хөлд үрэгдээд 1,2 жилийн дараа бүр алга болох вий гэж бид хаана хаанаа бодох ёстой. Нутгийн хөгшид, сум орон нутгийн хариуцлагатай ажил хийж байсан хүмүүс анхааралдаа авах хэрэгтэй. За бидэнд газарчилж бидний ажилд тусласан та бүхэнд баярлалаа.